

БАТЛАВ: ЭРДЭНЭБҮРЭНГИЙН
УСАН ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ



“ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ ТӨСӨЛ”-ИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН
“АМЬТНЫ АЙМГИЙН СУДАЛГААНЫ АЖИЛ”-ЫН ДААЛГАВАР

2024 оны 09 сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

Үндэслэл:

Улсын тусгай хэрэгцээний 28000 га талбай тэр дундаа төслийн нөлөөлөлд өртөх станцын барилга баригдах 117 га, нуур үүсэх 9871.1 га талбайд тухайн орчин дах амьтдын амьдрах орчин, тэдгээрийн тоо толгой, тархац нутгийг тодорхойлох; станцын барилгын бүтээн байгуулалтын үйл ажиллагаа амьтдын амьдрах орчинд хэрхэн нөлөөлөхийг тогтоох;

Ажлын даалгавар:

“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл”-ийн 2021 онд батлагдсан БОННУ тайланг үндэслэн амьтны аймгийн нарийвчилсан судалгааг хийж гүйцэтгэх;

Захиалагч байгууллага	ЭБУЦСтанц
Ажлын зорилго:	<p>Гүйцэтгэгч нь ажлын төлөвлөгөө, захиалагч талын өгсөн чиглэл зааварчилгаа болон байгаль орчны стандарт, дүрэм, журам, бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл”-ийн 9871.1 га талбай буюу Увс, Баян-Өлгий, Ховд аймгийн нутаг дэвсгэр дэх амьтны аймгийн нарийвчилсан судалгааны ажлыг гүйцэтгэнэ.</p> <p>Хээрийн судалгааг хийхээс өмнө 2 талын хооронд байгуулах гэрээ, хээрийн судалгаа болон нийт зардлын тооцоо, хээрийн судалгааны дэлгэрэнгүй төлөвлөгөө, төсвийн тооцооллыг “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төсөл хэрэгжүүлэгч нэгжид гүйцэтгэгч тал хүлээлгэн өгнө.</p>

Ажил гүйцэтгэх хугацаа:	Судалгааны ажлыг хийж гүйцэтгэх хугацаа Төсөл хэрэгжүүлэх нэгжтэй гэрээ байгуулснаас хойш 45 хоног байна.
Гүйцэтгэгчид тавигдах шаардлага	<p>Амьтан судлаач - Байгаль орчны мэргэжилтэн</p> <ul style="list-style-type: none"> • Байгаль орчин, амьтан судлалын чиглэлээр их, дээд сургууль төгссөн, магистраас доошгүй зэрэгтэй байх; • 10 болон түүнээс дээш жил мэргэжлээрээ тасралтгүй ажилласан, судалгаа шинжилгээ хийсэн байх; • Биологийн олон янз байдал, дүйцүүлэн хамгаалал, амьтны аймгийн чиглэлээр мэргэшсэн байх;
Гүйцэтгэх ажил	<p>Судалгааны ажлыг холбогдох хууль тогтоомж, журамд нийцүүлэн шинжлэх ухааны арга зүйн дагуу хийж гүйцэтгэнэ. Төслийн талбайд хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэхдээ хөхтөн амьтад, шувууд, мөлхөгч амьтдын тархац нутгийг тодорхойлох, төслийн үйл ажиллагаа амьтдын шилжилт хөдөлгөөн хэрхэн нөлөөлөхийг тогтоож зөвлөмж боловсруулна.</p> <p>“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл”-ийн талбайд хийгдэх судалгааны ажил дараах агуулгыг хамарсан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Төслийн талбайд хамаарагдах нугаламт амьтдын зүйлийн бүрдэл, байршил, тоо хэмжээ, тархалт, тэдгээрийн шилжилт хөдөлгөөн, амьдрах орчны үнэлгээ; • Нугаламт амьтдаас нэн ховор, ховор амьтад байгаа эсэхийг тодорхойлох; • Төслийн талбайд тэмдэглэгдсэн болон амьтдын үлдээсэн ул мөрийг судалж, фото зургаар баримтжуулах; • Станцын барилга байгууламж баригдаж эхлэхэд тухайн орчин дахь нугаламт амьтад, тэдгээрийн шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх нөлөөллийг тодорхойлох, зөвлөмж боловсруулах; • Станцын барилгаас боомт хүртэлх тээврийн хэрэгслийн сайжруулсан шороон замын амьтдад нөлөөлөх нөлөөллийг тодорхойлох, • Тээврийн зам дээр мал, амьтан өнгөрөх гарц, гүүрэн коридор зэрэг саадгүй нэвтрэх боломжийг тодорхойлох; • Шинээр үүсэх нуурын талбай амьтдын амьдрах орчинд хэрхэн нөлөөлөхийг тодорхойлох;

Ажлын тайлан хүргүүлэх	Тайланг бэлтгэхдээ тоон мэдээ, байрзүйн дэвсгэр зураг зэргийг хавсарган монгол хэлээр нэг хувь хэвлэмэл, цахим (word болон pdf) хэлбэрээр хүлээлгэж өгнө. Тайланг ТУХ (Төслийн удирдах хороо) эсвэл төслийн нэгжид тайлагнана.
------------------------	---

Судлаач нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажлын даалгаварт заасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд хийж, шаардлагатай судалгаа, шинжилгээ, тооцоо бусад ажлыг хугацаанд нь үнэн зөв чанартай хийж гүйцэтгэнэ.

Бүрдүүлэх материал:

- Судалгааны ажлыг гүйцэтгэх хүсэлт, анкет, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар/хуулийн этгээд/, боловсролын зэргийн диплом, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, бусад үнэмлэх, гэрчилгээний хуулбар;
- Ажлын туршлагыг тодорхойлсон дэлгэрэнгүй намтар/багийн гишүүн тус бүрээр/;
- Техникийн санал (үүрэгт ажлыг хийх аргачлал, ажлын төлөвлөгөө), санхүүгийн дэлгэрэнгүй санал (тусад нь дугтуйлсан байх);

Ажлын хөтөлбөр болон аргачлалын талаарх танилцуулга

- Ажлын хөтөлбөрийг дэлгэрэнгүй байдлаар хүснэгтээр гаргаж ирүүлнэ.
- Ажил гүйцэтгэх аргачлалыг дэлгэрэнгүй гаргаж ирүүлнэ.